



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 09 сарын 23 өдөр

Дугаар А/488

Мөрөн сум

Тусгай зөвшөөрөл олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Зөвшөөрлийн тухай хуулийн 1.5 дугаар зүйл, 5 дугаар зүйлийн 5.2, 5.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.3, 15.7, 15.9, Захиргааны ерөнхий хуулийн 40 дүгээр зүйлийн 40.2, 43 дугаар зүйлийн 43.1, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд, Эрүүл мэндийн сайд, Хууль, эрх зүй, дотоод хэргийн сайдын хамтарсан тушаал, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 05 дугаар сарын 02-ны ээлжит XVIII хуралдааны 15 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хуулийн этгээдийн хүсэлт, ажлын хэсгийн дүгнэлтийг харгалзан согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгосон хуулийн этгээдүүдийн нэрсийн жагсаалтыг хавсралтаар баталсугай.

2.Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн үйл ажиллагаанд хууль тогтоомжийн дагуу хяналт тавьж ажиллахыг аймгийн Цагдаагийн газар (Цагдаагийн хурандаа Д.Мөнхжаргал), аймгийн Хүнс, хөдөө, аж ахуйн газар (Я.Эрхэмбаяр), холбогдох сумдын Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

3.Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хууль болон бусад хууль тогтоомжийг мөрдөж, аймгийн Засаг даргын 2016 оны А/10, 2016 оны А/194 дүгээр захирамжаар батлагдсан цагийн хязгаарт нийцүүлэн үйл ажиллагаагаа явуулахыг согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчдэд үүрэг болгосугай.


4.Энэхүү захирамжийг эс зөвшөөрвөл оролцогчид мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор гомдол гаргах эрхтэй болохыг дурьдсугай.

5.Тусгай зөвшөөрлийн тэмдэгтийн хураамжийг аймгийн орон нутгийн орлогод төвлөрүүлж, тооцон ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Г.Базар), захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтэс (Р.Машбат) нарт тус тус даалгасугай.

ДАРГА

П.ЛХАГВАЖАВ

СОГТУУРУУЛАХ УНДАА ХУДАЛДАХ, ТҮҮГЭЭР ҮЙЛЧЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ ЖАГСААЛТ



Аймгийн Засаг даргын 2024 оны
09 дүгээр сарын 23-ны өдрийн
Анхдугаар захирамжийн хавсралт

№	Тусгай зөвшөөрөл эзэмшигч		Утасны дугаар	Тусгай зөвшөөрлийн төрөл
	Хуулийн этгээдийн нэр	Байршил		
1	"Ар цагаан хамрын оргил" ХХК	Галт сум 5-р баг Хайрхан 401 тоот "Бүрэн" мини маркет	99760904	Спиртийн өндөр агууламжтай согтууруулах ундаа худалдах
2	"Оргих булаг булган эрдэнэ" хоршоо	Галт сум 5-р баг Цагаан хамар 124 тоот "Оргих булаг" мини маркет	86130404	Спиртийн өндөр агууламжтай согтууруулах ундаа худалдах
3	"Өгөөж даваат" ХХК	Галт сум 5-р баг 4-8-17 тоот "Өгөөж" мини маркет	98384949	Спиртийн өндөр агууламжтай согтууруулах ундаа худалдах
4	"Ямаачин баатар" хоршоо	Галт сум Зүрх баг "Баян" супермаркет	86080769	Спиртийн өндөр агууламжтай согтууруулах ундаа худалдах
5	"Овооны хяр" хоршоо	Галт сум Зүрх баг "Арвижих" хүнсний дэлгүүр	89909127	Спиртийн өндөр агууламжтай согтууруулах ундаа худалдах

_____ооо_____